

ХЯТАД БА ЗӨВЛӨЛТ ОРОСЫН ХООРОНДОХ МОНГОЛ (1920—1924 он)

С. Г. Лузянин*

Сүүлийн жилүүдэд Оросын эрдэмтэн, судлаачид өөрийн орны нам, төрийн гадаад бодлогын түүхийн чухал асуудлуудыг олон улсын харилцаа, тухайлбал, Алс Дорнодын харилцааны түүхийн талаас нарийвчлан судалсан зохиол бүтээлүүдийг нийтлэх болжээ. Энэ нь ОХУ-ын нам, төрийн байгууллагын архивын материалуудыг (ялангуяа урьд хаалттай байсан) эрдэм шинжилгээний эргэлтэнд оруулж, судлаачдын хүртээл болгож байгаатай холбоотой.

Ийм судалгаа Монгол, Оросын харилцааны түүхийн асуудлаар мөн гарах боллоо. Тийм бүтээлийн нэг нь Монголын шинэхэн үеийн түүхийг судлагч, эрдэмтэн С. Г. Лузянины бичсэн «Хятад ба Зөвлөлт Оросын хоорондох Монгол (1920—1924 он)» (Алс Дорнодын асуудлууд, 1995. № 2) хэмээх өгүүлэл юм. Зохиогч өгүүлэлдээ хориод оны эхний Орос-Монголын. Монголоор дамжуулан Орос-Хятадын харилцааны байдал, энэ харилцааны эгзэгтэй хурц асуудлууд, тэдгээрийн шийдвэрлэлт, Монголын олон улсын эрх зүйн статусын асуудал зэрэг түүхчдийн анхаарал татсаар байгаа чухал чухал асуудлыг хөнджээ. Өгүүлэлд манай түүхийн одоог хүртэлх судалгаанд ашиглаж байгаагүй материалууд («Шинэхэн түүхийн баримт бичгүүдийг хадгалах ба судлах Оросын төв», «ОХУ-ын гадаад бодлогын архив»-ын материалууд)-ыг ашиглан, тэдгээрт үндэслэн өөрийн дүгнэлтүүдийг хийжээ. Ашигласан материал, хийсэн дүгнэлтүүдээр шинэлэг энэхүү өгүүлэл манай уншигчдын сонирхол татаж буй нь ойлгомжтой.

Иймд энэ нийтлэлтэй түүхчид-судлаачид, улс төрийн бодлоготон, эрдэм шинжилгээний уншигч олноос танилцахад дөхөм болгохын тул өгүүллийг орос хэлнээс орчуулан тус сэтгүүлийн хуудаснаа нийтэлж байна.

С. Г. Лузянин—Түүхийн ухааны дэд эрдэмтэн, Монголын шинэхэн үеийн түүхийг судлагч

1920—1924 оны Орос, Монгол, Хятадын хоорондын харилцааны түүхийг гадна байдлаас нь үзвэл Зөвлөлтийн болон Монголын уламжлалт түүх судлалд нэлээд өргөн дэлгэр судлагдсан байна. Түүний хамт энэ асуудлыг боловсруулахад зохиогчдын оруулсан ихээхэн хувь нэмрийг үл чамлан тэмдэглэхэд 60—80-аад оны зохиолуудад тэр үеийн түлхүүр үйл явдлуудыг гоён чимж, ямар нэг хэмжээгээр ёс төдий үнэлэх явдал голлож байсан бөгөөд энэ нь ч түүхэн үйл явдлыг бүхэлд нь үзэл сурталжуулах явдлаас урган гарч байсан биз.

Хятадын талаарх Зөвлөлтийн ба Монголын бодлогын аажим хувьсал хэрхэн явагдаж байсан, 1921 оны 6-р сард 5-р Армийн ангиудыг Хүрээнд оруулах, 1921 оны 11 дүгээр сарын 5-нд Зөвлөлт-Монголын хэлэлцээрт гарын үсэг зурах шийдвэрүүд нь ямар бодит шалтгаанаар тодорхойлогдож байсан зэрэг нь одоо хүртэл тод болоогүй байна. 1924 оны 5-р сарын 31-ний Зөвлөлт-Хятадын хэлэлцээрийн 5-р зүйлийг байгуулсан түүх эцэслэн судлагдаагүй бөгөөд тэгэх тусмаа, Зөвлөлтийн уламжлалт түүх судлалын үнэлэлтээр бол Гадаад Монголыг Хятадад «өгөх»-ийг Москва зөвшөөрсөн явдал нь ёс төдий (формал) акт бөгөөд хэрэг дээрээ Алс Дорнодод энх тайван амгалан байдлыг хадгалахын төлөө Хятадад буулт хийх зайлшгүй байдлаас урган гарсан юм гэдэг. Энэ алхам бол үнэхээр ЗСБНХУ-ын зүгээс хийсэн томоохон буулт байсан юм гэдгийг зөвшөөрөхийн зэрэгцээ түүний үнэнхүү учир шалтаг юу байв, Зөвлөлтийн удирдлагыг юу түлхэж байсан юм, Алс Дорнодод энх тайвныг хадгалах явдал уу, Хятадад «хувьсгалын түймрийг» асаах хүсэл үү, эсвэл стратегийн өөр зорилго уу гэдгийг нарийсган тодруулах нь хэрэгтэй юм. Үүнтэй холбогдон Монгол нь Москвагийн хувьд юу байв, Зөвлөлт-Хятадын харилцаан дахь «солионы хөзөр» байв уу, эсвэл эдгээр харилцааны бодит субъект, тэгэхдээ аль нэг асуудалд хандах өөрийн хандлага бүхий субъект байв уу?

Үүнтэй холбогдуулан дурдахад америкийн судлаач Брюс Эйдемааны саявтар нийтлүүлсэн өгүүлэл сонирхол татаж байна. Зохиогч өгүүлэлдээ Тайваний эх сурвалжид үндэслэн уг асуудлын талаар өвөрмөц хандлагыг үндэслэсэн байна. Гэвч энэ өгүүлэлд ч гэсэн Зөвлөлт, Монголын бодлогын аажим хувьсал мөн түүнчлэн Монголын асуудлыг «шийдвэрлэхэд» А. А. Иоффегийн гүйцэтгэсэн үүрэг зохистой тайлбарлагдсангүй.

Нэг өгүүллийн хүрээнд энэ бүх болон бусад асуудалд хариу өгөх нь хэцүү. Толилуулан буй өгүүлэлд судлах хэрэгтэй нь хэдийнээ тод болсон асуудлын заримыг Оросын төв архивуудад хадгалагдан буй урьд мэдэгдэхгүй байсан архивын шинэ баримт бичгүүдийн үндсэн дээр сөхөн тавих орлоллого хийж байна.

Коминтерн ба Монголын хувьсгал

Монголын талаар Зөвлөлт Засгийн газрын бодож боловсруулсан анхны алхмууд нь иргэний дайны үед хамаарны 1920 оны 12 дугаар сарын 17-ний өдрийн секцийн хурал-Засгийн газар ба Монголын ард түмэнд хандсан Зөвлөлт Оросын уриа» нийтлэгдсэн бөгөөд түүнд Алс Дорнод явуулах Зөвлөлтийн бодлогын ерөнхий зарчмуудыг илэрхийлж, Монголд холбогдох Хаант Орос Улсын гэрээ, хэлэлцээр, концессиудаас татгалзаад Богд гэгээний Засгийн газартай албан ёсны, тэгш харилцаа тогтоохыг санал болгожээ. Энэхүү уриа нь 1920 онд Хүрээнд ирсэн боловч хэрэг дээрээ хариу авалгүй үлдсэн байна.

Монголын талаарх Зөвлөлт Орос улсын бодит бодлого нь 1920 оны 6 дугаар сард Эрхүүд байгуулагдсан ОК(б)Н-ын Сибирийн товчооны Алс Дорнодын ард түмнүүдийн секц, түүний Монгол-Түвдийн хэлтсийн нууц ажиллагааны хүрээн дэх хувьсгалт ажилд төвлөрч байв. Секц нь коминтерний салбарын хувьд Алс Дорнодын хил нийлсэн орнууд дахь «хувьсгалт дипломатын» гол төв байсан юм. Секцийн зорилт нь: Хятад, Монгол, Япон, Солонгост коммунист бүлгүүд, намуудыг бэлтгэн зохион байгуулах, эдгээр орон дахь сөрөг хүчинд цэрэг-техникийн тусламж үзүүлэх, үндэсний боловсон хүчний дотроос мэргэжлийн хувьсгалчдыг бэлтгэх, үзэл суртлын ажил явуулах, өөрөөр хэлбэл Дорно дахинд «хувьсгал экспортлох» гэж нэрлэж болох зүйлд холбогдох үйл ажиллагаа байсан юм. Энэхүү дурдсан зүйл нь коммунист хөдөлгөөнийг зохион байгуулах талаархи секцийн зааварчилгаанд тод туснагдаж байлаа. Тэдгээр зааварчилгын нэгэнд дурдагдаа: «...(комм, бүлгүүд-С. Л) бэлтгэгдэхийн хэрээр секц нь тэдгээрийг холбогдох орнуудад газар дээр нь ажлыг зохион байгуулан явуулахын тул илгээх бөгөөд Урьдчилан тэдгээрийг бие даасан намууд хэмээн ТХ-нд, түүгээр дамжуулан Коминтернд танилцуулан батлуулна...»²² гэжээ.

Секцийн Монгол дахь үйл ажиллагаа, 1921 оны 2 дугаар сараас Коминтерний Алс Дорнодын нарийн бичгийн дарга нарын газар болсон секцийн үйл ажиллагаа нь мөн л зохион байгуулалт-техникийн асуудлуудыг хөндөж байв. Жишээ нь. 1919 оны 7 дугаар сарын 25-нд «Автономит Монголын даан хэлэлцэх асуудлын төлөвлөгөө ёсоор Хятадын империализмтай тэмцэхийн тулд Монголын үндэсний нэгдсэн фронтыг байгуулах³; Монголын партизаны отрядыг бүрдүүлэн, тэдгээрийг зэр зэвсэг, сургагч нараар хангах; Монгол дахь хятадууд ба семеновынхний талаар монголын хувьсгалчдын бүлгээс баримтлах тактикийн асуудлуудыг хэлэлцсэн байна. Сүүлчийн асуудал хэлэлцээд хятадууд болон семеновынхний хоорондын тэмцэлд монголчууд төвийг сахиж тэдгээрийн хоорондын мөргөлдөөнд нэмэр үзүүлэхийг зөвлөсөн байна.⁴

Дээрээс 3 дахь, доороос 11 дэхь мөрийг сольж уншина уу.

1921 оны 2 дугаар сард Монголд Унгернээс өрнүүлсэн дэвхтэй үйл ажиллагаа (Хүрээг эзэлж, тэндээс хятадуудыг хөөсөн, Богд гэгээнийг ширээнд дахин залсан, Хүрээн дэх хувьсгалт бүлгийг бут ниргэсэн зэрэг) нь Коминтерний зорилтыг хүндрүүлж бас тодорхой болгож өгсөн байна. 1921 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн Алс Дорнодын нарийн бичгийн дарга нарын газрын тогтоолд: «Унгерн Монголыг эзэлсэн явдал нь Коминтерн ба Зөвлөлт Орос улс хувьсгалт баазаа алдах аюулыг бий болгов... Япон улс Семенов бүхий Тэнгис хавийн муж, Чжан Цзолинь бүхий Манжуур, барон Унгерн бүхий Монголоос бүрдсэн хар бүферийг байгуулж байна... Коминтерн ба Зөвлөлт Оросын дайчин зорилт нь энэхүү бүферийг, ядахдаа түүний Монголын хэсгийг эвдэхэд оршино»⁶ гэж заасан байна. Улс төрийн талаас авч үзвэл Коминтерний зорилт нь хялбардуу болсон бөгөөд учир нь одоо хүртэл торгоон барьж байсан—Хятадын хүчин зүйл хоёрдугаар зэрэгт оржээ. Ингэснээр энэ нь Монголыг чөлөөлөх үйл хэргийг «ангийн дайсныг» устгах шинж төлөвтэй болгож, үүний хамт Сибирийн хил хязгаарт аюултай байсан Монгол дахь түшиц газрыг устгах шинж төлөвтэй болгосон байна.

Цэрэг дайны хувьд гэвэл Унгерний Азийн морин дивизийг устгах хоёр вариант төлөвлөгдөж байжээ. Коминтерний Алс Дорнодын нарийн бичгийн дарга нарын газрын тэргүүн Б. З. Шумяцкий 1920 оны өвөл санал болгохдоо Монголын хувьсгалт отрядуудыг «өөш» болгон ашиглаж Унгернийг Зөвлөлтийн хил рүү ирүүлэх замаар устгах төлөвлөгөөг санал болгосон байна. Шумяцкийгээс Гадаад явдлын ардын комиссар Г. В. Чичеринд бичсэн нэг захидалдаа энэхүү төлөвлөгөө нь «Зөвлөлт Орос Улсад зүдэргээтэй... тэгээд ч хэрэггүй» аян дайныг Хүрээний чиглэлд явуулах явдалас зайлсхийх бололцоо олгоно гэж тэмдэглэсэн байна. Харин Алс Дорнодын Бүгд Найрамдах улсын Засгийн газрын боловсруулсан нөгөө хандлага нь Гадаад Монголын нийслэл рүү цэрэг дайны аялал хийхийг зөвлөсөн төлөвлөгөө байв⁷.

Энэхүү зөрөөтэй саналууд нь ер нь Монголыг «хувьсгалжуулах» явдал хэрэгтэй юу, үгүй юу гэсэн асуудлаар Зөвлөлтийн удирдлага дотор явагдаж байсан түүнээс өргөн маргааны нэг хэсэг байлаа. Жишээ нь, 1921 оны 6-р сарын 1-нд болсон ОК(б)Н-ын ТХ-ны Алс Дорнодын товчоо, ЗСБНХОУ-ын ГЯАК, 5-р Армийн хувьсгалт цэргийн зөвлөлт, АДБНУ-ын Засгийн газрын төлөөлөгчдийн хамтарсан хуралдаанаар Монголын талаар явуулах хувьсгалт бодлогын асуудлаар хурц тэмцэл өрнөсөн байна.. АДБНУ-ын зарим удирдагч тэдний дотор Ерөнхий сайдын орлогч Н. М. Матвеев, мөн түүнчлэн Армийг командлагч (командарм) А. Матияевич нар хуралдаан дээр хэлэлцэгдэж байгаа Хүрээг чиглэсэн цэргийн аян дайныг эрс эсэргүүцэж, энэ нь «улс төрийн олиггүй адал явдал мөн»⁷ гэж нэрлэв. 5-р Армийн командлагч хэлсэн үгэн дотроо «Хүрээг эзлэх явдал нэг хэрэг. Унгерний тухай асуудал өөр хэрэг, Унгерн цэрэг дайны хувьд

бидэнд заналхийлж чадахгүй. Унгерний тухай асуудлыг Хүрээг эзлэх явдлаас ангид авч үзэх хэрэгтэй. Энэ нь диплома — тын асуудал юм»⁸ гэсэн байна.

Нөгөө бүлэг улс төрчид-АДБНУ-ын ерөнхий сайд А. М. Краснощеков, АДБНУ-ын Цэргийн сайд Н. Буров өөр байр суурь баримталж Хүрээг эзлэх явдал бол чухамхүү Улс төрийн талаас ач холбогдолтой бөгөөд энэ нь Монгол ба Хятадад хувьсгалт хөдөлгөөнийг дэмжихэд хэрэгтэй гэж үзэж байв.

Хуралдааны төгсгөлийн тогтоолд: «а) Монголын операц нь АДБНУ ба ЗОУ-ын хүчийг илтгэн харуулахад, манай ар талыг хангахад, Чжан Цзолиний үйл ажиллагааг эсэргүүцэх арга болгоход, Хятад ба Монголд хувьсгалт давхрааг бэлтгэхэд чухал болно; б) Зорилго нь — Унгернийг бүрэн Устгах... Хүрээг ба хил дагуу нутгийг «цэвэрлэх», тэнд Монголын үндэсний Засгийг тогтооход оршино; в) Тогтох засаг нь үндэсний байхаас биш, зөвлөлт засаг байхгүй, тавих зорилго нь Монголыг бие даалгах бус, харин Хятадтай холбооны үндсэн дээр харилцах автономийг тогтоох явдал байна» гэж бичжээ.

Санал хураахад ОК (б) Н-ын ТХ-ны АД товчооны бүх гишүүн, АДБНУ-ын Цэргийн сайд Н. Буров, ГЯАК-ын бүх төлөөлөгчид «Зөвшөөрч», Ерөнхий сайдын орлогч Н. Матвеев, Армийн командлагч А. Матиясевич, Ерөнхий командлагч Н. Лапин нар «үл зөвшөөрчээ»⁹.

«Хувьсгалт аяллын» тухай шийдвэрийг Москвад тайван хүлээж авчээ. 1921 оны 6 дугаар сарын 16-нд ОК (б) Н-ын ТХ-ны Улс төрийн товчооны хурлаар Улаан Арми ба АДБНУ-ын цэргийн ангиудыг Монголд оруулах тухай Удирдамжийг баталжээ¹⁰. 5 дугаар Армийн бүрэлдүүнээс К. А. Нейман ба Г. М. Черемисинов нараар командлуулсан аялан дайлах корпусыг томилон гаргав, Корпус 1921 оны 6 дугаар сарын 28-нд Сүхбаатарын монгол цэргийн хамт Хиагтын район хавиар хилийг даван гарч Хүрээний зүг хөдлөв. 6 дугаар сарын 5-6-нд аялан дайлах корпусын ангиуд эсэргүүцэл үзэлгүйгээр (Унгерн Зөвлөлтийн аялан дайлах цэрэг орохоос өмнө нийслэлийг орхин гарсан) хотод орж ирэв. 6 дугаар сарын 8-нд Бодоо тэргүүтэй «Хиагтын» хувьсгалт түр засгийн газар шилжин ирж, Засгийн эрх теократ засгийн газраас Монголын хувьсгалчдын гарт шилжсэнийг тунхагласан байна. Богд гэжээний статусыг хэмжээт эрхт хааны хүрээнд хадгалан үлдээв¹¹.

Болсон үйл явдлын үнэлэлтийг Монголын хувьсгалыг «урлан бүтээгчдийн» нэг Б. З. Шумяцкий уг операц төгсөнгүүт өгсөн юм. 1921 оны 8 дугаар сарын 12-т Г. В. Чичеринд бичсэн захидалдаа: «Өөрийн үндэсний нэгдлийн, зарим талаар оршин тогтохуйн хувь заяагаа Зөвлөлт Орос улстай холбосон тодорхой найз нөхдийг бид бий болгов. Энэ нь монголын олон түмэн юм. Манай мянган километрийн хил хязгаарын эмзэг газруудыг халхлан байх холбоотныг ... бид өөртөө бий болголоо... Бид Монголтой тайван цагийн аж ахуйн харилцааг эхлэх бололцоог олж авлаа»¹² гэж тэр бичжээ.

Гэвч монголын бодлогын талаарх үнэлгээ бүгд адилхан эерэг байсангүй. Зөвлөлтийн нэрт дипломатуудын нэг А. А. Иоффе 1922 онд Хятадад байхдаа В. И. Ленин, Л. Д. Троцкий, Г. Е. Зиновьев, И. В. Сталин болон Зөвлөлтийн бусад удирдагчдад бичсэн улс төрийн нэг захидалдаа: «Монголыг зөвлөлтжүүлэх явдал бодож боловсруулсан зохион байгуулалттай тууштай төлөвлөгөөний үр дүн болсонгүй. Хэрэв Монголд Унгерн байгаагүйсэн бол манай нөхөд тэнд яарахгүйсэн, Дорнод Түркестаныг (Синьцзян С. Л), хэдийгээр мөн тэнд Бакирт байсан ч гэсэн, зөвлөлтжүүлээгүйн адил бид Монголыг зөвлөлтжүүлэхгүй байсан юм... нөхөр Чичерин орон нутгийн мулгуучуудад зохих хариулт өгч чадаагүй билээ»¹³ гэж бичжээ.

1921 оны Монголын хувьсгал нь хэрэг дээрээ хоёр эсрэг тэсрэг үзэгдлийг, тухайлбал нэгдүгээрт, монголчуудаас 1911-1912 оны үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний пан монголизмийн үзэл санаа, хятадын эсрэг лозунгийн үндсэн дээр суверенитет (бүрэн эрх), тусгаар тогтнол өөд тэмүүлсэн уламжлалт тэмүүлэл, хоёрдугаарт, Монгол нь дэлхийн хувьсгалыг дорнод дахинд өрнүүлэх ерөнхий стратеги дахь хувьсгалт бодлогын чухал объект гэж үзсэн Зөвлөлт Орос ба Коминтерний гадаад нөлөө хоёрыг өөртөө нэгтгэн нийлүүлсэн юм. Энд дурдсан зүйлийн сүүлчийн хандлага нь Хятад дахь ГЯАК-ын дипломат, шупам бодлогоос нэлээдгүй «түрүүлж» Монголын асуудал ирээдүйд хурцдах, будлих явдлыг нөхцөлдүүлсэн юм.

«Буферийн» дипломат бодлого ба Монгол

1920 оны 7 дугаар сард Хятад ба АДБНУ-ын хооронд эдийн засгийн ба дипломатын албан ёсны харилцаа тогтоох зорилгоор Бээжинд И. Л. Юринээр толгойлуулсан АДБНУ-ын төлөөлөгчдийг илгээв. Төлөөлөгчид Хиагтын Маймачинд хэд хэдэн удаа саатсаны дараа 1920 оны 8 дугаар сарын 21-нд Бээжинд хүрэлцэн ирж Хятадын дорнод төмөр замын тухай асуудал, худалдааны хэлэлцээрийн төслийг хэлэлцэх ажилд орсон байна¹⁴. Эн үед Гадаад Монгол Хятадын (Аньфугийн бүлэглэлийн) эрхшээл мэдэлд байсан хийгээд Коминтерн тэнд хувьсгалт төлөвлөгөөнүүдийг дөнгөж боловсруулан эхэлж байсны улмаас улс төр ба дипломатын харилцаанд Монголын асуудал хурцаар тавигдаагүй байсан тул И. Л. Юрины хэлэлцээний явцад энэ нь тусгайлан хөндөгдөөгүй байна¹⁵. Төлөөлөгчдийн хийсэн хэлэлцээний ганц үр дүн нь хилийн харилцаа холбоо ба төмөр замын хөдөлгөөний журмын тухай хэлэлцээрийг байгуулж 1921 оны 3 дугаар сарын 7-нд Манжуур хотод парын үсэг зурсан явдал байв¹⁶.

Унгерн Монголыг байлдан эзэлж, Коминтерн «хувьсгалт аяныг» идэвхтэй бэлтгэсний дараа байдал эрс өөрчлөгдөв. Хятадаас буцаж ирээд АДБНУ-ын Гадаад явдлын сайдаар томилогдоод байсан И. Л. Юринд Дээд Үд хот руу Г. В. Чичерин 1921 оны 6 дугаар сарын 27-нд яаралтай бичиг илгээж, түүндээ «Хятадтай мөргөлдөх аюул өдрөөс өдөрт хурцдаж байна. Монголын автономийн үндсэн дээр, Хятадын сувере-

нитетийг хүлээн зөвшөөрөх үндсэн дээр монголын асуудлыг зохицуулахаар Бээжин явагтун. Манай цэрэг дайны үйл ажиллагаа нь Хятадын дайсан Унгернд цохилт өгөх зорилготой, бид Хятадын эрхийг хүлээн зөвшөөрч байгаа бөгөөд дайсныг устгантуу л зайлан гарна гэдгийг тайлбарлагтун»¹⁷ гэжээ.

1921 оны 7 дугаар сарын эхээр Хятадад хоёрдох удаа очсон И. Л. Юрины айлчлал Монгол дахь үйл явдалтай шууд холбоотой байв. Хятадын тал Монголын асуудал ул суурьтай хэлэлцэхийг татгалзсан хэдий ч хэлэлцээнд энэ асуудлыг И. Л. Юрин албан ёсоор тавьсан явдал нь Гадаад Монголын ирээдүйн статустын талаарх Бээжингийн байр суурийг АДБНУ-аар дамжуулан Москва тандаж мэдэх оролдлого хийж буйг илэрхийлсэн хэрэг болсон юм. Тэгэхдээ оросын тал мэдээжийн «Хиагтын системийн»¹⁸ зарчмууд, тухайлбал Хятадын сюзерениет (эзэнт эрхийн) дор байх өргөн автономийн вариантаас иш үндэс авсан байна¹⁹. АДБНУ-ын удирдлага Москвагай тохиролцсон үндсэн дээр И. Л. Юрины байр суурийг нотлон Бээжингийн Засгийн газарт нэмэгдэл тусгай мэдэгдлийг 1921 оны 8 дугаар сард хийж, түүндээ «Монголын байдал» нь Монголын талаар Хятадтай байгуулсан Оросын хуучин Хаант засгийн гэрээнүүдээр тодорхойлогдоно... АДБНУ-ын Засгийн газар нь Монгол Хятадаас салан одоход үл хүргэнэ»²⁰ гэж мэдэгсэдн байна.

Монголын хувьсгалчид ба Хятад

Өрнөдийн зарим нийтлэлд Монголын хувьсгалт нам нь Коминтерн ба Зөвлөлт Орос анхнаас захирагдмал байсан бөгөөд энэ нь тэдний бодлоор гадаад бодлогын болон бусад асуудлаар Монголын бие даасан байр суурийн тухай асуудлыг ярих хэрэггүй болгодог гэсэн тезис бат нот баримталдаг болсон байна²¹. Хэдийгээр бүрэлдэн тогтсон хамаарал байсан ч гэсэн Монголын хувьсгалт удирдлага гадаад харилцааны асуудлуудаар өөрийн хандлагатай байснаар барахгүй, тэд өөрийн үзэл баримтлалдаа аажим хувьслын үеийг туулан гарсан байна.

Зөвлөлт Орос, Монгол, Хятадын ирээдүйн харилцааны талаарх өөрийн мөрийн хөтөлбөрийг монголчууд анх удаа тоймлон боловсруулсан хэлбэрээр Монголын хувьсгалчдын төлөөлөгчид 1920 оны 8 дугаар сард Эрхүү хотод Сибирь, Алс Дорнодыг хариуцсан ГЯАК-ийн төлөөлөгч Ф. И. Галонтой хийсэн хэлэлцээний явцад илэрхийлсэн юм. Анхны уулзалт дээр монголчууд мэдэгдэхдээ: «1. Гадаад Монголын Ардын хувьсгалт нам²² нь Хиагт хотод 1915 онд байгуулсан Орос Хятад-Монголын гурван этгээдийн гэрээний тэгэхдээ автономийг өргөтгөх, Гадаад Монголын талаархи Орос, Хятадын давхар протекторатыг Устгахад чиглэсэн зарим зүйлийг хассан үндсэн дээр Гадаад Монголын автономийг сэргээхийг эрмэлзэнэ...; 2. Хятадын хувьсгалт бүлгүүд, байгууллагуудтай нягт холбоо хэлхээг тогтооно... Үүний хамт Хятадад дипломат нөлөөлөл үзүүлэх утгаар Зөвлөлт Оросын Засгийн

газарт хандан тусламж эрнэ. 3. Өөрийн нөлөөг Монголын бүх хэсэгт (Дотоод Монгол, Барг—С. Л.) дэлгэрүүлж, тэдгээрийг Хятадтай федераци буюу автономийн аль нэг хэлбэрээр холбогдсон нэгэн бүхэл улс болгон ирээдүйд нэгтгэнэ»²³ гэсэн билээ. Энэхүү мөрийн хөтөлбөрөө Монголчууд 1920 оны намар Москвад Г. В. Чичеринд танилцуулсан байна.

Монголд Хятадын албан ёсны дэглэм тогтож байсан нөхцөлд Монголын хэрэгт Зөвлөлт Оросыг илэрхий «оролцуулах» болгоомжлон Зөвлөлтийн удирдлага энэ үед Монголчуудын саналд хянуур хандсан юм. Эрхүүд ч гэсэн, Москвад ч гэсэн Монголын төлөөлөгчдөд цэрэг-техникийн ба санхүүгин тусламж үзүүлэх, Коминтерний шугамаар, түүний Монгол-Түвдийн хэлтсээр дамжуулан хувьсгалт нууц ажлыг хүчтэй болгохоо амлажээ²⁴.

Эрхүүгийн хэлэлцээний үеэр сонсогдсон «Хятадын федерацийн» үзэл санаа Хиагтад 1921 оны 3 дугаар сарын 1-3-нд батлагдсан Монгол Ардын Намын «Платформад» (мөрийн хөтөлбөр)-т дахин тэмдэглэгдсэн байна. Түүнд дурдахдаа: «Нам Дундад иргэн Улсын бүх мужийг тус тус болгон... тэдгээрийн хооронд гэрээний үндсэн дээр федератив холбоо тогтоохыг зүйтэй гэж үзэн, хэрэв Умард Хятад, Түвд... Манжуур, Монгол тус бүр өөртөө автономит эрх тогтоон, хоорондоо федерацийн байгуулал батжуулбал энэ федерацийн холбоонд монголын ард түмэн ороход саад болох шалтгаан байхгүй»²⁵ гэжээ. Өөр нэгэн баримт бичиг—«Хятадын бүх ард түмэн, Хятадын коммунист нам, үйлдвэрчний эвлэл, оюутан болон Хятадын бүх хувьсгалт бүлэгт» гэсэн МАҮ-ын ТХ-ны 1921 оны 3 дугаар сарын 25-ны Урианд «федерацийн» үзэл санааг Хятадын хувьсгалт хөдөлгөөн болон «тус Улс империалистууд, дудзюнуудын (орон нутгийн цэргийн эрхтэн—С. Л.) эрх мэдлээс чөлөөлөгдөх явдлын» ирээдүйн амжилттай холбон үзсэн байна²⁶.

Дурдсанаас үзвэл, хувьсгалын өмнөхөн үед Монголын хувьсгалчдын байр суурь хоёр зүйлээр тодорхойлогдож байсан бөгөөд **нэгдүгээрт**, Хятадын ард түмнүүдийн ирээдүйд бий болох федерацийн хүрээнд Хятадын үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнтэй Монгол Ардын нам ойртох хувьсгалт зүй зохисоор; **хоёрдугаарт**, гурван этгээдийн харилцааны харилцан буулт хийсэн хэлбэр болон Гадаад Монголын автономит статусыг өөртөө агуулсан хуучин «Хиагтын системийн» нөлөөгөөр тодорхойлогдож байв. Орос Монголын 1911-1917 оны албан ёсны харилцааны туршлага нь Зөвлөлт Монголын эхэн үеийн хэлхээ холбоонд шууд бишээр дамжин шилжиж, хоёр талд дадал болсон «Монголын автономи», «Хятадын сюзеренитет», «Оросын зуучлал» гэсэн ухагдахууныг «сэхээн амьдруулах»-ад илрэлээ олсон юм.

Зөвлөлт-Монголын 1921 оны 11 дүгээр сарын 5-ний хэлэлцээр

Зөвлөлт-Хятадын харилцаан дахь Гадаад Монголын статусын тодорхой бус байдал 1921 оны 7 дугаар сарын үйл явдлын дараа Улам нэмэгдэж Монголын Засгийн газрыг дэм-

жиж, түүнтэй хэлэлцээр байгуулах нь цаашдаа зүй зохистой эсэх асуудлаар Зөвлөлтийн удирдлага дотор Улс төрийн хурц маргааныг нөхцөлдүүлжээ.

Зөвлөлт Оросын хувьд геополитикийн болон хувьсгалт зорилтын үүднээс авч үзвэл 1921 оны хувьсгалын үр дүнг Монголын Ардын Засгийг албан ёсоор хүлээн зөвшөөрөх явдлаар бататгах, хэрэптэй байв. Гэвч ГЯАК-ийн өмнө тавигдаж байсан Хятад дахь дипломат байр сууринаас авч үзвэл энэ хэлэлцээр байгуулах нь нэн ашиггүй байсан бөгөөд яагаад гэвэл Бээжингийн Засгийн газартай албан ёсны харилцаа тогтоох талаарх будилсан асуудлыг Улам төвөгтэй болгох байлаа. Дүрслэн хэлбэл, Монголын хувьсгал ба Коминтерн хоёр Алс Дорнод дахь Зөвлөлтийн дипломат бодлогыг тодорхойлж байсан билээ.

Хэлэлцээр байгуулах үзэл санааг «хөдөлгөгч», зоригжуулагч нь Б. З. Шумяцкий байсан бөгөөд 1921 оны 10 дугаар сарын эхээр Монголын төлөөлөгчидтэй хамт Москва ирэнгүүт Монголыг албан ёсоор хүлээн зөвшөөрүүлэх талаар Зөвлөлтийн удирдлагыг итгүүлэх, ухуулах эрчимтэй ажлыг өрнүүлжээ. Гэвч түүний дэвшүүлсэн Гадаад Монголын талаарх Оросын анхаарч үзүүштэй учирлал аргумент нь ГЯАК-ын нэг хэсэг ажилтны (Л. М. Карахан, А. А. Иоффе болон бусад, хүчтэй эсэргүүцэлтэй тулгарсан агаад тэд «зуучлал хийхийн өмнөхөн (Хятад, Монголын хороонд—С. Л.) салангид хэлэлцээр байгуулахаар үсчих нь зарчмын талаар боломжгүй тухай...» түүнд ил мэдэгдэж байсан байна²⁷.

1921 оны 10 дугаар сарын эхний хагасын туршид ГЯАК ба Коминтерний гүйцэтгэх хорооны хүрээнд 3 хуралдаан, 2 тусгай комиссийн хурал болж, энэ асуудлыг хэлэлцэж хурц маргалдсан байна. Хадгалагдан буй баримт сэлтээс үзвэл Б. З. Шумяцкийг өндөр үнэлж, Монголын асуудлаарх түүний мэдлэгт итгэдэг байсан Г. В. Чичерин Шумяцкийг дэмжих тийш хандаж байжээ. Хэлэлцээр байгуулахын төлөөний нөгөө нэг чансаатай учирлал аргумент нь энэ үед Монгол орон Зөвлөлт Оросын хувьд геополитикийн ач холбогдолтой байсан явдалтай холбоотой байв. 1921 оны 10 дугаар сарын 18-нд В. И. Ленинд бичсэн захидалдаа Г. В. Чичерин: «Хувьсгалт Засгийн газар нь (Монголын С. Л.) бидний гарт байгаа нэг томоохон хөзөр юм. Энэ засгийн газар байгуулагдсан явдал Номхон дөлгөөн далайгаас Каспийн тэнгис хүртэл хувьсгалын эсрэг фронт тогтоох Японы төлөвлөгөөнүүдийг хөмрүүлэн Няцаасан билээ. Манай асар урт хил хязгаар нь нөхөрсөг Монголоор халхалагдсаны хувьд бүрэн аюулгүй»²⁸ гэж дурджээ.

Явагдсан маргаан мэтгэлцээний дүнд хэлэлцээг хийхээр тогтсон бөгөөд Б. З. Шумяцкий өөрийгөө чөлөөтэй байлгахын тулд хэлэлцээнд албан ёсны төлөөлөгч болон оролцохоос татгалзаж, «хөшигний ард» байгаа мэтээр ажиллаж, хэрэг дээрээ Зөвлөлтийн хүнд суртлын бүтэцтэй байгууллагуудаар хөөцөлдөн Монголд нэг сая цагаан мөнгөний зээл

олгохоос эхлээд монголын мөнгөн тэмдэгтүүдийг хэвлүүлэх захиалгыг хийх мэтийн тусгай асуудлуудыг бэлтгэх талаар асар их ажил явуулж байсан байна.

Хэлэлцээ 1921 оны 10 дугаар сарын дундуур эхэлжээ, түүнд монголын талаас Данзан (МАН-ын ТХ-ны дарга, Төлөөлөгчдийн ахлагч), Сүхбаатар (цэргийн сайд, ерөнхий командлагч), Цэрэндорж (Гадаад явдлын дэд сайд, Автономит Засгийн газарт ажиллаж байсан, үлэмж туршлагатай улс төрийн бдлоготон), Ширнин-дамдин (Богд гэгээний төлөөлөгч), орчуулагч Бутынхан нар; Зөвлөлтийн талаас С. Н. Духовский, Б. В. Гец нар оролцжээ.

Хэлэлцээ эхлэнгүүт Монгол Хятадын харилцааны асуудал тодрон гарч, үүнтэй холбогдон Гадаад Монголын статусыг тодорхойлох хэрэгтэй болсон байна. Хэлэлцээ эхлэхэд монголчууд анхныхаа «автономийн» байр суурийг орхиж, Гадаад Монголын байдлыг «Хятадаас тусгаар» байдал гэж тайлбарлав. Энэхүү аажим хувьсал нь 8 дугаар сард буюу «ЗСБНХОУ-ын Засгийн газар Зөвлөлтийн цэргийг Монголд үлдээхийг зөвшөөрч буй тухай» ЗСБНХОУ-ын ГЯАК-аас Монголын Засгийн газарт илгээсэн ноотод «Автономит Монгол»²⁹ гэсэн нэр томъёог хоёр удаа хэрэглэсэн үеэс эхэлсэн бөгөөд энэ томъёолол нь Монголын байдлыг тусгаар тогтносон байдал³⁰ хэмээн үзэх болсон МАН-ын ТХ ба Засгийн газрын удирдлагын ихэнх хэсгийн эрс дургүйцлийг төрүүлсэн юм. Удалгүй «Автономит Монгол» гэдэг нэр томъёо зөвлөлт монголын албан ёсны барим бичгүүдэд дурьдагдахаа больжээ.

Зөвлөлтийн Удирдлагын байр суурь нь Оросын зуучлал ба Гадаад Монголын автономийн үндсэн дээр гурван талын хэлэлцээг Хятадад нээх бодолтой байв, Гэвч Хятадтай ирээдүйд хийх хэлэлцээнд монголчуудын оролцох хэлбэрийг нарийвчлах хэрэгтэй байлаа. Б. Шумяцкий, Г. В. Чичерин нарын бодлоор үүнийг ЗСБНХОУ-ын төлөөлөгч (А. К. Пайкес) болон дараагаар нь Монголын ихээхэн туршлагатай, нэр хүндтэй дипломат Цэрэндорж нар Хятадад ирсний дараа хийх хэрэгтэй гэж үзэж байв. Үүний хамт Зөвлөлтийн тал Монголын түрүү үеийн баримт бичгүүдийг иш үндэс болгож хэлэлцээрт Монголын байдлыг «...Бүгд Найрамдах Хятад улсын ард түмнүүдийн ирээдүйн федератив холбооны ...автономит эрх бүхий» хэсэг хэмээн тодорхойлох саналтай байв³¹.

Энэхүү саналыг монголчууд няцаасан бөгөөд үүний дараа тунхаглалууд солилцож тэдгээрт харилцан хийх буултуудыг олжээ. «Чөлөөт Монгол Улс Оросоор зуучлуулан Бүгд Найрамдах Хятад Улстай ойрын үед хийх хэлэлцээ нь саад тогторыг хурдан арилгахад хүргэнэ»³² гэж Зөвлөлтийн удирдлага мэдэгдэв. Зөвлөлтийн тунхаглал дахь «Чөлөөт Монгол» гэсэн нэр томъёог Данзан болон төлөөлөгчдийн бусад гишүүн Монголын тусгаар тогтнолыг дэмжиж буй зөвлөлтийн удирдлагын чиг шугамын нотолгоо гэж хүлээн авав.

Хэлэлцээний явцад өмнөхөөс дутуугүй хурц өөр хоёр асуудал болох Урянхайн хязгаар (Тува)-ын тухай, хуучин оросын концессиудын тухай асуудал гарч ирсэн байна. Концес-

сийн тухайд гэвэл, эдгээр концессийг шинээр хэн нэгэнд өгөх болбол Орос улс гурав дахь талын эрх эдлэнэ гэсэн Зөвлөлтийн саналыг монголчууд эсэргүүцэв. ГЯАК-аас 1920 оны намар Монголын төлөөлөгчдөд мэдэгдсэн мэдэгдлийг Данзан давтан ишлэж, Зөвлөлт Засгийн газар хуучин хаант Оросын концессиос ямар нэгэн тайлбаргүйгээр бүрэн татгалзвал зохино эгж мээдгдэв.

Урианхайн асуудлаар энэ хязгаар нутаг нь Монголын Ардын Засгийн газрын мэдэлд захирагдан байх болно гэсэн зүйлийг хэлэлцээрийн текстэнд оруулах саналыг Данзан гаргав. ГЯАК-ын талбан ёсны үзэл нь Урианхайн ард түмэнд 1921 оны 9 дүгээр сарын 9-нд Г. В. Чичерины илгээсэн ноотод өгүүлэгдсэн бөгөөд энэ нь: Зөвлөлт Орос Улс энэ газар нутгийн өөртөө засан тохинох эрхийг «Монголын эрх чөлөөний хөдөлгөөнтэй»³³ холбон үзээд түүнийг өөрийн газар нутаг хэмээн үзэхгүй гэснээр тодорхойлогдож байсан юм. Энэхүү мөлчгөрдүү томьёололын цаана нэн тодорхой шалтгаан байжээ. Монголын олон улсын байр улсын нь хувьд тодорхойлогдоогүй байхад Монгол Тува хоёулан Хятадын гарт орчих вий гэж болгоомжлохгүйгээр Тувааг Монголд бодитойгоор шилжүүлэх тухай ярих нь эртэднэ гэж Зөвлөлтийн удирдлага үзэж байсан нь үндэсгүй ч биш байв.

Урианхайн болон концессийн асуудлын улмаас хэлэлцээ тасрахад дөхөж очсон байлаа. Энэ хямралын талаар Б. З. Шумяцкий хожим дурсан нэрт коминтернч, Монголын Армийн хувьсгалт зөвлөлтийн тэргүүлэгч Э. Д. Ринчинод илгээсэн нэгэн захидалд бичихдээ: «Хэлэлцээний үед бүх юмыг хаяад хандсан зүгтээ арилж одмоор мөч тохиолдож байв. Үүний шалтгаан нь Данзан болон бусуудд үйл хэргийн ашиг тусыг огт ойлгохгүй байсан явдал юм... Данзан үнэхээр л ойлгохгүй байна, Хүрээ бол... яах аргагүй найдвартай шүү гэдгийг манай ажилтан нарт сэнхрүүлэхэд 3 өдрийг зарцуулсан билээ»³⁴ гэжээ.

1921 оны 11 дүгээр сарын 5-нд «Орос, Монголын хооронд нөхөрсөг харилцаа тогтоох тухай ЗСБНХОУ-ын Засгийн газар ба Монголын Ардын Засгийн газрын хоорондын Хэлэлцээрт» гарын үсэг зурав. Оршил хэсэг, 13 зүйлээс бүрдсэн хэлэлцээрийн төгсгөлийн текст нь мөлчгөрдүү бөгөөд харилцаан буулт хийсэн баримт бичиг болсон юм. Харилцан тохиролцсон ёсоор хэлэлцээрт Гадаад Монголын олон улсын эрх зүйн статусын тухай, түүнээс Хятадтай харилцах харилцааны тухай зүйлүүд, Урианхай хязгаарын тухай зүйл ороогүй юм. Концессийн тухай асуудлыг 1921 оны 11 дүгээр сарын 5-ны өдрийн «Хэлэлцээрийн нэмэгдэл Протоколд» оруулж, түүгээр Оросын концессиудыг шинэ хувь нийлүүлэгчдэд шилжүүлэх үед Зөвлөлт Орос «гурав дахь талын» эрх эдлэх болсон байна³⁵. Үүний хамт Монголд зориулсан мөнгөн тэмдэгтүүдийг Москвад хэвлэх тухай, цаасан мөнгө гаргах болон бусад хэрэгцээнд зориулан Монголын Ардын Засгийн газарт цагаан мөнгөөр нэг сая банкны зээл олгох тухай нууц хэлэлцээрүүдийг байгуулжээ³⁶.

Зөвлөлт Орос, Монголын хооронд 1921 оны 11 дүгээр сарын 5-ны өдөр байгуулсан хэлэлцээр нь Зөвлөлт-Монголын улс төрийн холбоог бүрдүүлэхэд анхны олон Улсын акт болсон бөгөөд Монгол аргагүйн эрхээр энэ холбоонд захирагдмал, бие даасан бус роль гүйцэтгэх болсон байна. Үүний хамт хэлэлцээр нь 1917-1920 оны «самуун цагийн» үед тасарсан орос-монголын уламжлалт холбоо хэлхээг бодитой сэргээжээ. Монголыг Зөвлөлт Оросын зүгээс албан ёсоор хүлээн зөвшөөрснөөр Монгол төрт ёсоо хадгалах, ирээдүйд Хятадзас бүрэн тусгаар тогтнох улс төр, цэргийн тодорхой баталгааг олж авчээ. Зөвлөлтийн талд гэвэл энэхүү хүлээн зөвшөөрсөн явдал нь үзэл суртлын (Алс Дорнодод үндэсний хувьсгалт хөдөлгөөнийг дэмжих) санаа бодлоос гадна, Улсын ашиг сонирхлын үүднээс ашигтай болж, Хятад, Японтой гарч болох мөргөлдөөнд хил дээрээ нөхөрсөг Улс-«буферийг» буй болгосон юм.

Хятад дахь Зөвлөлтийн анхны дипломатууд ба монголын асуудал

Москва ба Хүрээнд хэлэлцээрт гарын үсэг зурсан ялалтыг баяртай тэмдэглэсэн. Гэвч үүнээс өмнө болж өнгөрсөн үйл явдлууд, тухайлбал Хүрээнд цэрэг оруулсан, ардын засгийг тунхагласан, Москвад хэлэлцээ хийсэн, хэлэлцээрт гарын үсэг зурсан зэрэг нь зөвхөн оршил дохио төдий зүйл байсныг цаашдын үйл явдал харуулсан юм. Түгшүүр дүүрэн, гэнэтийн явдал ундарсан жинэхнэ хэрэг үйлс 1921 оны 12 дугаар сарын 12-нд ЗСБНХОУ-ын төлөөлөгч А. К. Пайкес Бээжинд ирсний дараа болсон билээ.

А. К. Пайкесын хэлэлцээний хөтөлбөрийн «Монголын хэсгийг» гурван талт «арга барил» буюу мэдээжийн зүйл-хэлэлцээнд Монголын төлөөлөгчдийг оролцуулах, оросуудаар зуучилуулах, Гадаад Монголд автономийг олгох явдал дээр үндэслэн төлөвлөсөн байжээ. Энэхүү хөтөлбөр нь Зөвлөлт Монголын хэлэлцээний үеэр Г. В. Чичерин, Б. З. Шумяцки болон А. Г. Пайкес өөрийн нь шууд оролцоотойгоор бэлтгэгдсэн байлаа. Зөвлөлтийн удирдлага Гадаад Монголын оршин тогтнох талаарх хүлээн авч болохуйц хэлбэрийг Хятадтай ярилцан олох, тэгэхдээ нэгэнт байлдан олсон байр суурийг үл алдах, өөрийн цэргийг болон Монгол-Зөвлөлтийн 1921 оны 11 дүгээр сарын 5-ны тохиролцоог хадгалах бодолтой байжээ. Тэгэхийн хамт Зөвлөлтийн тал байдал айхавтар ноцтой байсныг, мөн Хятад дотооддоо хямралдаантай ч Монголын асуудлыг шийдвэрлэх зөвлөлтийн «арга барилыг» зарчмын хувьд хүлээн авах эрмэлзлэлгүй байсныг бүрэн дүүрэн анхаарч үзээгүй байжээ. Хаант Орос цаг үедээ болгоож чадсан зүйлийг Зөвлөлт Орос давтах боломж нэгэнт үгүй болсон байжээ. Түүний дээр А. К. Пайкес Бээжин орохоор мордохдоо Зөвлөлт Монголын хэлэлцээрийн тухай дугуй өнгөрөхийг хичээх гэсэн Москвагийн тактикийн алдаатай удирдамж авч явсан тул түүний аялал нь ямар нэгэн

хэмжээгээр урьдаас бүтэлгүй шинжийг олсон байлаа³⁷. Бээжингээс ирсэн анхны мэдээ ерөнхий болгоомжлолыг нотоллоо. Ийм мэдээний нэг болох 1921 оны 12 дугаар сарын 27-нд Г. В. Чичеринд ирүүлсэн цахилгаанд «Хятадын засгийн газар Монголтой харилцаагаа зохицуулахаас нааш Монголоос цэргээ гаргахгүй» гэж Чжан Цзолиний төлөөлөгчдөд мэдэгдсэн тухайгаа тэр мэдээлжээ³⁸. Зөвлөлт-Монголын хэлэлцээрийн тухай авагдсан мэдээлэлтэй холбогдуулан түүний бие буруушаал зэмлэлийн дайралтанд нэрвэгдэж байгаагаа 1922 оны 1-р сард мэдээлсэн байна. Буруушаал зэмлэл хэвлэл дээр ч гарч, албан ёсны шугамаар ч хийгджээ. Хятадын ГЯЯ 1922 оны 5 дугаар сарын 1-нд Монголын талаар А. К. Пайкест тусгай албан бичиг өгч, түүндээ «Та Бээжинд ирээд тийм зүйл (зөвлөлт-монголын хэлэлцээр-С.Л.) байхгүй гэсэн, саявтар хувийн ярианы үеэр энэ гэрээний текстийг үзүүлэхэд гэрээ бий гэдгийг Та хүлээн зөвшөөрсөн... Манай Засгийн газар Танд эрс эсэргүүцэл илэрхийлэн, Ажилчин-Тариачны Засгийн газраас Монголтой байгуулсан бүх гэрээг Хятадын Засгийн газар хүлээн зөвшөөрөхгүй гэдгийг мэдэгдэж байна»³⁹ гэжээ.

Хүчтэй дарамт байсан ч А. К. Пайкес Москвагийн зааврыг хэрэгжүүлэхийн төлөө эцсээ хүртэл тэмцсэн байна. 1922 оны 2 дугаараас 6 дугаар сард Пайкес «Монголын суверенитетийн» тухай буюу «Хятадын сюзеренитетийн» тухай хэлэлцээнд Монголын Засгийн газар оролцох ёстой юү, үгүй юү, эсвэл Хятад Монголын хооронд Зөвлөлт Орос зуучлагч болох уу гэдэг талаар Хятадын ГЯЯ-ны төлөөлөгчидтэй урт удаан, зүдгүүртэй маргаан явуулсан байна⁴⁰. Үүний хамт тэр бээр өөр асуудлууд, тухайлбал Хятадын Дорнод төмөр зам, Хаант Орост төлөх хятадын өр гэх мэт асуудлыг хэлэлцэхийг оролдсон авч, Монголын асуудал хэлэлцээний ерөнхий явцыг тодорхойлж, түүний Урьдчилсан шийдвэрээс төлөөлөгчдийн ажлын амжилт бүхэлдээ хамаарч байсан юм. Ийнхүү Монголын асуудлын талаарх Москвагийн анхны байр суурь И. Л. Юрины дараа Хятадад илгээсэн хоёр дахь дипломат төлөөлөгчдийн үйл ажиллагаа бүтэлгүйдэн сүйрэх явдлыг нөхцөлдүүлсэн байна.

ЗСБНХОУ-ын шинэ дипломат төлөөлөгч А. А. Иоффе 1922 оны 7 дугаар сард Хятадад ирсэн явдал төлөөлөгчдийг ёс төдий сольсон явдал бус, энэ нь Зөвлөлтийн Удирдлага Хятадад хандах талаар түүний дотор Монголын асуудлаар хандах талаар зарчмын шинэ хандлагыг хайсан эрэлхийлэл байсан юм. Сүүлчийн асуудал нэлээд төвөгтэй байсан талаар А. А. Иоффед ч хуурмаг бодол байгаагүй. Москвагийн удирдлагад бичсэн улс төрийн анхны захидлын нэгэндээ: «Монгол бол манай Хятадын талаарх бодлогод хамгийн эмзэг газар, манай эсрэг империалистуудын гэр дахь цорын ганц хөзөр юм»⁴¹ гэж бичсэн аж. А. А. Иоффе өөрийн үүрэгт ажлаа эхлэхдээ Монголын талаарх байр сууриа үндсээр өөрчлөх хэрэгтэйд Москваг итгүүлэх, өөрөөр хэлбэл гурван талын хэлэлцээ, Гадаад Монголын автономийн үзэл санаа, мөн түүнч-

лэн И. Л. Юрин, А. К. Пайкес нарын хийж байсан шиг Монголын асуудлыг дангаар буюу урьдчилан тусгайлан хэлэлцэхээс татгалзаж түүнийг ерөнхий бага хурал дээр бусад асуудлын хамтаар авч үзэх нь хэрэгтэй гэдэгт Москваг итгүүлэх зорилго тавьсан байна⁴².

А. Иоффегийн анхны захидлуудыг хэлэлцсэн ОК (б) Н-ын ТХ-ны Улс төрийн товчоо энэ саналыг эерэг бус хүлээн авч автономийг үлдээх, хэлэлцээнүүдэд монголын засгийн газрыг оролцуулах зэргийг зөвшөөрүүлэх гэсэн хуучин шаардлагууд бүхий Удирдамжийг түүнд 1922 оны 9 дүгээр сарын эхээр илгээж, энэ нь «Хятадын суверенитетийг үл зөрчинө»⁴³ гэж тэмдэглэсэн байна.

Ийм нөхцөлд хэлэлцээг аврах, Г. В. Чичерин, Л. Д. Троцкий, Г. Е. Зиновьев болон бусдыг итгүүлэх үүднээс Хятад ба Монголын үйл явдалд хийсэн өөрийн нарийвчилсан задлан шинжилгээний үр дүн болсон илүү дорвитой учирлал аргументыг гаргасан байна.

А. Иоффе тайлбарлахдаа: **нэгдүгээрт**, Монголоос «татгалзах явдал нь» Хятад дахь хувьсгалт хөдөлгөөн, эцсийн дүнд дэлхийн хувьсгалд тус хүргэх юм гэжээ. Цааш нь бичихдээ, Хятадын хувьсгалын өвөрмөц тал нь Хятадад «автономизм» (автономит ёс) хэмээх ойлголттой адилтган үздэг мужийн цэргийн эрхтэн-дудцзюнуудийн эсрэг явуулж буй өмнө зүгийнхний тэмцэлтэй холбоотой билээ. «Монголын автономизмыг» дэмжиж буй Зөвлөлтийн дэмжлэгийг Хятадад үзэхдээ түүний дотоод хэрэгт нь оролцож байгаа явдал... түүнээс ч дор, Сун Ятсений эсрэг хандсан хувьсгалын эсрэг байр суурь гэж үздэг юм»⁴⁴ гэсэн байна.

Хоёрдугаарт, Монголыг Хятадад шилжүүлэн өгөхийн зүй зохисыг тодруулан тэмдэглэхдээ А. Иоффе үндэстний өөртөө засаг тохинох эрхийн асуудлыг хөндөж, энэ эрх нь лавдуу биш, харьцангуй болохыг Зөвлөлтийн удирдлагад сануулсан байна. Тэр бичихдээ: «Бид заримдаа жижигхэн армян ард түмний ашиг сонирхлыг том турок ард түмний ашиг сонирхлын үүднээс огоордог нь маш зөв, учир нь турокүүдийн үндэсний хөдөлгөөн нь дэлхийн хэмжээн дээр... армянуудын үндэсний тэмцлээс... хавьгүй чухал юм... гээд тэр цааш нь тэмдэглэхдээ, бид монголын ард түмэн гэж сүрлэгээр нэрлэдэг. Монголын буриадуудыг сэтгэлдээ нэн дотно байлгаж, тэдний төлөө манай Алс Донодын бүх бодлогыг, түүнээс ойлгох манай бүх дэлхийн хувьсгалыг хохироох ёстойг би огтхон ч ойлгохгүй байна»⁴⁵ гэжээ. А. Иоффе үүнээс иш үндэс авч, монголчуудын өөртөө засаг тохинох эрх. Хятадаас тусгаарлан салах эрх нь хувьсгалт хөдөлгөөний асар их зорилтуудтай холбогдон «хротои бөгөөд хэрэгцээгүй» зүйл болж байна гэсэн дүгнэлт хийжээ.

«Аугаа их үзэл санааны» төлөө иймэрхүү «хувьсгалт» эрээ цээргүй явдал гарган, бүхэл бүтэн ард түмэн, Улс орны хувь заяагаар худалдаа наймаа хийх нь тэр үед дэлгэрсэн үзэгдэл болж байжээ. А. Иоффе ул чанартаа 1919 онд ОК (б) Н-ын VIII их хурал дээр үндэстний йөөртөө засаг тохинох эрхийн

асуудлаар явагдсан маргаан мэтгэлцээний үед сонсогдож байсан санаа бодлыг цааш хөгжүүлсэн юм. Их хурал дээр В. И. Лениний мөрийн хөтөлбөрийн төсөл, тухайлбал үндэсний бодлогын тухай бүлгийг хэлэлцсэн юм. Илтгэлийн талзар үг хэлсэн Н. И. Бухарин үндэсний бодлогын үндсэнд үндэстний өөртөө засан тохинох эрхийг биш, харин бүх үндэстний пролетари нар нэгдэх тухай тезисыг тавивал зохино гэж мэдэгдээд өөрийн зүгээс «Үндэстэн тус бүрийн хөдөлмөрч ангиудын» өөртөө засан тохинох эрхийг тунхаглах санал оруулжээ. Пролетари анги бүрэлдэн бий болоогүй улс оронд «Үдэстний өөртөө засан тохинох эрх» байж болох юм гэж Н. Бухарин үзжээ. Тэр хэлэхдээ, хэрэв бид «үндэстний өөртөө засан тохинох эрхийн» тухай лозунг колониудад зориулан дэвшүүлбэл бид юу ч алдахгүй, харин хожих болно, учир нь үндэсний бүх цогцос зүйлс нь харь орны империализмд хор хохирол учруулах болно»⁴⁶ гэжээ. Өөрөөр хэлбэл Н. Бухарин энэхүү «эрх»-ийг ангийн зүй зохисоос иш үндэс авч нэг тохиолдолд олгож, нөгөө тохиолдолд олгохгүй байх цаг зуурын ухуулгын шинжтэй «эрх» гэдгийг заан харуулсан байна. «Намын хайрт хүнийг» Г. Д. Пятаков болон Ардын комиссар нарын зөвлөл дэх В. И. Лениний орлогч А. И. Рыков нар дэмжив. Лениний энэхүү үндэслэл Мөрийн хөтөлбөрт орсон агаад дэлхийн хувьсгалт хөдөлгөөний явцаас хамааран хэрэглэгдэх хөтөлбөрийн энэхүү зүйл ёс төдий «дайварын» шинжтэй болохыг л маргаан мэтгэлцээн харуулсан болно.

Монголыг «шилжүүлэн өгөх» нь хэрэгтэй болох талаарх А. Иоффегийн дэвшүүлсэн сүүлчийн учирлал аргумент нь Хятад дахь Улс төрийн хүчний хуваарилалттай холбоотой байв. Тэр үед Коминтерний баримжаалж байсан Сун Ятсен болон түүний цаг зуурын холбоотон У Пэйфу нар нэгдсэн, төвлөрсөн Хятадыг байгуулахын төлөө тэмцэж байсан бөгөөд Гадаад Монголын автономи нь тэрхүү Хятадад «багтан орохгүй» байв. Зөвлөлтийн цэрэг Монголд түр «саатах» асуудлаар Сун Ятсен болон У Пэйфу нар 1922 онд Иоффег дэмжинэ гэсэн боловч Хятадын лидерүүд өөр өөрийн тооцоотой байсан байна. Сун өөрийн сая хүнтэй армийг Сычуаниас Монголын хил орчим шилжүүлэх асар том төлөвлөгөөгөө биелүүлэхэд Монгол ба түүний ард байсан ЗСБНХУ-ыг материал-техникийн бааз ба түшиц газар болгон ашиглахаар төлөвлөж байсан бол⁴⁷ У Пэйфу ер нь А. Иоффед мэдэгдэхдээ түүний цэрэг 1923 оны хавар Зөвлөлтийн цэргийн ангиудыг зүгээр л орлон солих болно, тэгэхэд Монголын тухай асуудал аяндаан шийдэгдэх болно гэж байсан байна. Бас Чжан Цзолин нь байсан бөгөөд тэр нь аман дээрээ Монголын автономийн үзэл санааг дэмжиж байлаа. Гэвч А. Иоффе манжуурын захирагчийн мэдэгдэл үнэн эсэхэд ихээхэн эргэлздэг байсан бөгөөд тэр нь анхны таатай тохиолдолд Монголыг эзлэн авахад бэлэн байсны дээр Чжан нь Сун Ятсенаас ялгаатай нь Хятад дахь ЗСБНХУ болон Коминтерний стратегийн холбоотон байгаагүй юм.

Дээр дурьсан дучир шалтгааныг иш үндэс болгон А. Иоффе

хэлэлцээг явуулах дараа дурдсан тактикийг санал болгосон байна. Үүнд:

А) Ирээдүйн хэлэлцээрт анхаарлыг Монголд төвлөрүүлэхгүй, Хятадын суверенитетийг ЗСБНХУ хүлээн зөвшөөрсөн ганцхан зүйлээр (статья) хязгаарлах; Б) 1921 оны Зөвлөлт-Монголын хэлэлцээрийг хадгалан үлдээх, хэрэв хятадууд түүнийг хүчингүй болгохыг шаардвал «түүнийг албан ёсоор авч үзэхгүй» байхыг Хятадад санал болгох; В) Монголоос өөрийн цэргийг гаргахад ЗСБНХУ бэлэн гэдгийг зарлан, гаргах хугацааг Зөвлөлт-Хятадын баримт бичгүүдэд гарын үсэг зурсны дараа болно хэмээн тайлбарлах⁴⁸.

А. Иоффеийн «хөтөлбөр» нь Москвад төвөг бэрхшээлтэй ч гэсэн өөртөө зам мөр гаргасан байна. Зөвлөлтийн удирдлага Монголын талаарх хэлэлцээг явуулах тактикийн шугамыг бүхэлд нь зөвшөөрсөн боловч нөлөөллийн өөр сувгуудыг ашиглан автономийг хадгалан хамгаалах найдварыг хараахан алдаагүй байв. 1923 оны намар Чан Кайшийн төлөөлөгчид Москвад айлчлах явцад Л. Д. Троцкий, Г. В. Чичерин нар монголын автономийн тухай үзэл санааг дахин босгон Гадаад Монголд өөртөө засан тохинох эрх олгох тухай асуудлыг авч үзэхийг Гоминданы генеральд санал болгосон бөгөөд энэ нь Чан Кайшийн ихээхэн дургүйцлийг хүргэж, ЗСБНХУ-ын бодлогод бүхэлд нь үл итгэх явдлыг хүчтэй болгожээ⁴⁹.

Япон руу илгээсэн А. И. Иоффегийн оронд Л. М. Караханаар удирдуулсан албан ёсны дипломат төлөөлөгчид 1923 оны 9 дүгээр сарын 5-нд Бээжин ирэв. Энэ үед Монголын талаарх А. Иоффегийн үзэл санааг Хятад дахь хувьсгалт хөдөлгөөний хэрэгцээгээр төрөн гарсан зайлшгүй хатуу шаардлага хэмээн Москва ойлгон авсан байна. Монголын талаархи А. Иоффегийн «үзэл баримтлал» нь уг чанартаа Л. М. Караханы хэлэлцээний үндэс болж, тэр нь мөнхүү хэргиг албан ёсоор барагдуулсан байна. Бусад асуудал (ХДТЗ, өрийн төлбөр гэх зэрэг) амаргүй байсан ч Л. Караханы хэд хэдэн удаагийн албан ёсны мэдэгдлийн дараа Монголын асуудал хоёрдугаар байр сууринд шилжив. Ингээд 1924 оны 2 дугаар сард «Үндсэний гадаад бодлогын нийгэмлэг»-ийн төлөөлөгчидтэй Л. Карахан Бээжинд уулзахдаа «Монголын тухай асуудал нь шалихгүй асуудал байв. Монгол нь Бүгд Найрамдах Хятад улсын бүрэлдэхүүнд орно гэж бид үзэж байна. Монгол дахь Хятадын суверенитетийн асуудалд бид эргэлзэхгүй байна» гэж хэлсэн байна⁵⁰.

Монголын талаарх Л. М. Караханы олон тооны мэдэгдэлтэй холбогдуулан Бээжин дэх Японы элчин сайдын яамны «Норс Чайна Стандарт» сонин сонирхол татах тайлбар нийтэлжээ. Сонинд бичихдээ: «Большевикийн төлөөлөгч анх удаа Монгол бол Хятадын хэсэг юм гэж хүлээн зөвшөөрөв. Одоо монголчуудыг тэдний чөлөөлөгчид нь гаргуунд хаяв, Учир нь том ашиг сонирхол тэргүүн байранд тавигдав. Ноён Карахан ганц л зорилготой иржээ. Энэ нь Хятадын Дорнод

төмөр зам болон Зөвлөлт Засгийн газрыг хүлээн зөвшөөрүүлэх явдал юм»⁵¹ гэжээ.

Бээжингийн хэлэлцээ дуусч, монголын асуудлаарх Москвагийн байр суурь өөрчлөгдсөн нь Монгол дахь Зөвлөлтийн төлөөлөгчдийн тактикт илрэн мэдэгдэв. 1924 оны 1 дүгээр сарын 3-нд Улаанбаатарт хүрэлцэн ирсэн ЗСБНХУ-ын шинэ бүрэн эрхт төлөөлөгч А. Н. Васильев, Г. В. Чичеринээс Монголын Удирдлагын доторх Хятадын эсрэг хүсэмгүй санаа бодолд ихээхэн анхаарал хандуулж, тэдгээрийг арилгахад бүх зүйлийг хийж, «автономи удаан хугацаанд» байна гэдгийг ухамсарлахад монголчуудыг дөхүүлэх зааварчилпа авч ирсэн байна⁵². 1924 оны 2 дугаар сард «Ургинские новости» сонинд өгсөн ярилцлагадаа элчин сайд «өнөөгийн байдалд Монголын тусгаар тогтнолын тухай ярьж боломгүй байна.

Одоохондоо Танай улсын автономийн тухай ярих хэрэгтэй болоод байна»⁵³ гэжээ.

Үүний хамт Монголын статусын тухай Улаанбаатар дахь дипломатын шинэ тайлбар сэлтээс үзвэл Монголд ЗСБНХУ-ын байр суурь суларсан шинж тэмдэг гараагүй. Харин ч 1924 оны 5 дугаар сарын 20-нд Богд гэгээн нас барж, мөн оны 11 дүгээр сарын 26-нд «тусгаар тогтносон Бүгд Найрамдах Монгол Ард Улсыг» тунхагласан нь улс төрийн хувьд ЗСБНХУ болон Коминтернтэй үзэл суртлын талаар цаашид ойлгосныг харуулав. «Их хурлаас баталсан Үндсэн хууль нь бүтцийн талаар түүнийг (Монголыг—С. Л.) Зөвлөлт төрлийн улсад ойртуулав» гэж Коминтерний шинэ төлөөлөгч Т. Рыскулов Коминтерний Төвийн гүйцэтгэх хороонд мэдээлж байв⁵⁴

Олон улсын талбарт гэвэл БНМАУ ба ЗСБНХУ-ын хувьд Урианхайн (Тува) статусын тухай асуудал нээлттэй хэвээр үлджээ. Монголын Засгийн газар түүнийг БНМАУ-ын бүрэлдүүнд оруулахыг шаардсаар байв. Гэтэл Зөвлөлтийн удирдлага Бээжинтэй ойлгож байсан нөхцөлд 1921 оны 11 дүгээр сарынхаас илүү шийдэмгий нэгтгэхийн эсрэг байж, үүнийгээ Туваг Хятад эзлэн авах аюул занал хүчтэй болж байгаагаар тайлбарлаж байв⁵⁵. Үүний хамт Дотоод Монголын ач холбогдол өсөв, учир нь Хятад дахь хувьсгалт хөдөлгөөний хөгжилтэй холбогдон Коминтерн МАХН-ын ТХ-г тэнд хувьсгалт хөдөлгөөнийг шууд удирдах байгууллага, БНМАУ-ыг түүний хүн хүч, эд материалын нөөц гэж бодитой үзэх болжээ.

1924 оны 5 дугаар сарын 31-нд Бээжинд дараа дурдсан баримт бичгүүдэд парын үсэг зурав. Үүнд:

1. ЗСБНХУ ба Бүгд Найрамдах Хятад Улсын хоорондын асуудлыг зохицуулах ерөнхий зарчмуудын тухай хэлэлцээр;

2. Хэлэлцээрийн зарим үндэслэлийг нарийсгасан тунхаглалууд;

3. Дипломат харилцаа тогтоох тухай ноотууд;

4. ХДТЗ-г түр удирдаж байх тухай хэлэлцээр.

«...Асуудлыг зохицуулах ерөнхий зарчмуудын тухай хэлэлцээрийн» 5 дугаар зүйлд Гадаад Монголыг «Бүгд Найрамдах Хятад Улсын бүрэлдүүн хэсэг» гэж тодорхойлжээ. Үүний хамт ЗСБНХУ өөрийн цэргийг Монголоос харилцан тохиролц-

сон хугацаанд гаргахад бэлэн байгаа тухай албан ёсоор Л. М. Карахан мэдэгдэв⁶⁹.

Зөвлөлтийн удирдлага Монголын асуудлаар гурван талын систем ба автономис Хятадын хууль зүйн бүрэн суверенитетийг хүлээн зөвшөөрөх хүртэлх нарийн ярвигтай, эмзэг зовиуртай аажим хувьслын замыг туулжээ. Иймэрхүү буулт нь Хятадын хувьсгалын, түүгээр дамжуулан дэлхийн хувьсгалын ирээдүйн төлөвөөр юуны өмнө нөхцөлдсөн байна. Үүний хамт энэ алхмаар зөвлөлтийн удирдлага нь Хятад дахь өөрийн тактикийн зорилтыг шийдвэрлэж, өмнөдөд холбоотноо хадгалан, умардад холбоотныг—Бээжингийн албан ёсны Засгийн газрыг—олж авсан байна.

Монголын хувьд гэвэл ЗСБНХУ Хятадын суверенитетийг хүлээн зөвшөөрсөн ч гэсэн Монголд Коминтерн ба Элчин сайдын яамны төлөөлөгчдөөр дамжуулан ажиллаж өөрийн нөлөөг өдрөөс өдөрт өргөжүүлсээр байв. Илүү өргөн утгаар авч үзвэл ЗСБНУ-ын монголын «буулт» нь хувьсгал—ангийн зарчим зөвлөлтийн дипломат бодлогод зонхилж байсныг илтгэх боловч тэр хоёрын (хувьсгал—ангийн ба төр—дипломатын) хооронд нэлээдгүй зөрөөн, зөрчил ажиглагдаж эхэлсэн байна. Хятадын хувьсгал нь «дэлхийн түймрийг» асаах гэсэн большевикүүдийн сүүлчийн найдвар байсан бөгөөд үүний тулд жижиг үндэстэн, Улс орныг түймрийн галд хаяж, олон улсын эрхийн нормуудыг хайхрахгүй байж болно гэж тэд сэтгэж байсан ажээ.

Орос хэлнээс орчуулж хэвлэлд
бэлтгэсэн академич Б. Балдоо

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ИШЛЭЛ

1. Bruce A. Elleman. Secret-Sino-Soviet Negotiations on Outer Mongolia 1918—1925. Pacific Affairs, Vol. 66, No. 4, 1993—1994. p. 519—539.
2. Шинэхэн түүхийн баримт бичгүүдийг хадгалах ба судлах Оросын төв, ф. 495, т. 154, хн. 21, хууд. 81,—Цаашдаа ШТБХСОТ гэж товчилно.
3. 1919 оны 11 дүгээр сард Бээжингийн Засгийн газар Хятадын милитарист Сюй Шучжэни цэргийн тусламжтайгаар Гадаад Монголын автономийг устгаж, Богд гэгээний засгийг хүчингүй болгосон байна—С. Л.
4. ШТБХСОТ, ф. 495, т. 154, хн. 89, хууд. 3,
6. Мөн тэнд хн. 9, хууд. 10—11,
66. Мөн тэнд хн. 9, хууд. 10—11,
7. Мөн тэнд ф. 372, т. 1, хн. 61, хууд. 57—59,
8. Мөн тэнд, хууд. 59,
9. Тэнд, хууд. 57,
10. Мөн тэнд, ф. 17, т. 3, хн. 176, хууд. 1.
11. Тодорхой зүйлийг Б. Ширэндэб. История Монгольской Народной революции. 191 г, М., 1971. 9омын 221—267 талд үзнэ үү.
12. ШТБХСОТ, ф. 5, т. 1, хн. 2145, хууд. 38,
13. Мөн тэнд, ф. 5, т. 1, хн. 2145, хууд. 38.
14. Тодорхой зүйлийг М. А. Персиц. Дальневосточная

Народной революции 1921 г. М. 1971, номын 221—267 талд үзнэ.

республика и Китай, М., 1962. номоос үзнэ үү.

15. Оросын холбооны улсын гадаад бодлогын архив, ф. 11, т. 4, прт. 5, пап. 2, хн. 190, хууд. 2,—Цаашид ОХУ ГБА гэж товчилно.

16. Капица М. С. Советско-китайские отношения. М. 1958. тал. 64.

17. ОХУ ГБА, ф. 11, т. 4, порт. 5, пап. 1, хн. 190, хууд. 2.

18. Орос-монголын 1912 оны, Орос-Хятадын 1913 оны, Орос, Гадаад Монгол, Хятадын гурван талын Хиагтын 1915 оны зэрэг цуврал хэлэлцээрүүдийн үр дүнд Гадаад Монголын байдал нь Хятадын бүрэлдүүнд «өргөн автономи» байхаар, тэгэхдээ бас Оросын талаас нэлээдгүй хяналттай байхаар тодорхойлогдсон юм. Энэ тухай тодорхой зүйлийг С. Г. Лузянины 1911-1917 оны Орос-Хятадын харилцаан дахь Монгол өгүүллийг (Хятадын уламжлалт соёл ба модернизацийн асуудлууд. Олон улсын э/ш бага хурлын илтгэлүүдийн тезис. М. 1994, 1 хэсэг, 181—184 тал) үзнэ үү.

19. ОХУ ГБА, ф. 11, т. 4, порт. 5, пап. 1, хн. 190, хууд. 2.

20. ШТББХСОТ, ф. 495, т. 154, хн. 97, хууд. 32.

21. R. Rupen, Now Mongolia is Really Ruled. A Political Stanford, 1979; P. S. H. Tang. Russian and Soviet Policy in Manchuria and Outer Mongolia 1911—1931. Durham. 1959.

22. Энд хувьсгалт бүлгийн тухай яригдаж буй бөгөөд нам нь 1921 оны 3 дугаар сарын 1-3-нд Хиагтад албан ёсоор байгуулагдсан.—С. Л.

23. ШТББХСОТ, ф. 495, т. 152, хн. 4, хууд. 3.

24. Тэнд, ф. 495, т. 152, хн. 10, хууд. 1.

25. Тэнд, хн. 9, хууд. 34.

26. Тэнд, хн. 20, хууд. 8.

27. Тэнд, ф. 495, т. 152, хн. 9, хууд. 72.

28. Тэнд, ф. 495, т. 152, хн. 9, хууд. 40.

29. Советско-монгольские отношения. 1921—1940, Документы и Материалы. М.—У. 1975, т. 1, с. 36.

30. ШТББХСОТ ф. 495, т. 154, хн. 97, хууд. 33.

31. Тэнд, ф. 495, т. 152, хн. 9, хууд. 34.

32. Тэнд, хн. 9, хууд. 47.

33. Тэнд, ф. 495, т. 152, хн. 9, хууд. 73.

34. Тэнд, хн. 9, хууд. 73—74.

35. Советско-Монгольские отношения. 1921—1940 с. 58—62

36. ШТББХСОТ, ф. 495, т. 152, хн. 11, хууд. 70; хн. 9, хууд. 57.

37. Пайкест зөвлөмж болгохдоо, арга барагдвал 1921 оны 3 дугаар сарын 7-нд И. Л. Юрины байгуулсан манжуурын хэлэлцээрийн Цицикар мужийн талаар тохиолдсон зүйлийг ишлэл болгоорой гэсэн бөгөөд нарийвчлан хянавал энэ адилтгал нь зөвлөлт-монголын хэлэлцээртэй огт тохирохгүй зүйл байсан юм.—С. Л.

38. ШТББХСОТ, ф. 5, т. 1, хн. 2194, хууд. 40.

39. ОХУ ГБА, ф. Караханы нарийн бичгийн дарга нарын газар, т. 5, порт. 19, пап. 3, хн. 110 (Ки), хууд. 1.

40. ШТББХСОТ, ф. 5, т. 1, хн. 2194, хууд. 73; хн. 2145, хууд.

хэлэлцээрийн Цицикар мужийн талаар тохиолдсон зүйлийг ишлэл болгоорой гэсэн бөгөөд нарийвчлан хянавал энэ адилтгал нь зөвлөлт-монголын хэлэлцээртэй огт тохирохгүй зүйл байсан юм-С, Л,

41. Мөн тэнд, хн. 2145, хууд. 15.
42. Мөн тэнд, хууд. 3.
43. Мөн тэнд, хууд. 166.
44. Мөн тэнд, хууд. 17.
45. Мөн тэнд, хууд. 78.
46. ОК (б) Н-ын VIII их хурал. Москва, 1919 оны 3-р сарын 18—23. Дэлгэр. тайлан, м. 1919. хууд. 41—42.
47. ШТББХСОТ, ф. 5, т. 1, хн. 2147, хууд. 32.
48. Тэнд, ф. 5, т. 1, хн. 2145, хууд. 79.
49. А. М. Григорьев К оценке итогов поездки делегации Гомандана в Москву в 1923 г. (Китайская традиционная культура и проблемы модернизации Тез. докл. V Междун. науч. конф. ч. II. М. 1994. с. 47—48.
50. ОХУ ГБА, ф. Монголын талаарх реферантура, т. 7. Пап. 2, Порт. II. хн. 720, хууд. 22.
51. Мөн тэнд, хууд. 27.
52. Мөн тэд, хууд. 198.
53. Мөн тэнд, хууд. 18—19.
54. ШТББХСОТ. ф. 495, т. 152, хн. 24. хууд. 142.
55. Мөн тэнд, хн. 9, хууд. 73.
56. Советско-китайские отношения. 1917—1957. Сборник документов—М., 1959, с. 83.

Туйлын нууцын нууц

1934 оны 11 сарын 15-ны өдөр,

**НӨХӨР СТАЛИНААС МОНГОЛЫН ТӨЛӨӨЛӨГЧ НАР
ЛУГАА ЯРИЛЦСАН ЗҮЙЛИЙН ТОВЧ ТЭМДЭГЛЭЛЭЭС**

Энэхүү ярилцаанд суулцсан хүмүүс нь:

Сталин, Молотов, Ворошилов, Каганович, Жданов, Скольников, Элиав, Гэндэн, Чойбалсан, Мэнд, Дашчираб, ба орчуулагч Илиян болно.

Нөхөр Сталинаас ...Одоо тусгаар тогтнох тухай хэлье, Танай улс болбол үнэндээ тусгаар тогтносон амой, Танай тусгаар тогтносныг гагцхүү СССР-ээс зөвшөөрсөн хэмээхийг би мэдмүй, Тийм биз, та нар болбол албан ёсоор Хятадаас салаагүй бөгөөд тийнхүү салсан тухай зарлаагүй болой, тийм үү,

Гэндэнгээс: тийм, үнэн, СССР-ээс өөр хэнд боловч батлагдаагүй бөгөөд Хятадаас албан ёсоор салаагүй амой гэсэнд,

Нөхөр Сталинаас: Танай улсын дотор Хятадын ямар нэгэн албан төлөөлөгч буй, үгүй та нар бусад улсаас та нарыг зөвшөөрөхийг хүсэх, та нараас тэд нар лугаа албан харилцаа тогтоохыг хүсэх эсэх, та нараас бусад улсын төлөөлөгчид лүгээ энэ талаар ярилцаж байсан эссэн хэмээсэнд,

Гэндэнгээс: Хятадын төлөөлөгч манай улсад байхгүй болой, Бусад улсыг зөвшөөрүүлэх тухай би оролдсонгүй болой, ямар ч нэгэн гадаад улсын төлөөлөгч нар лугаа энэ тухай би ярилцаагүй болой хэмээсэнд,

Нөхөр Сталинаас: Тийм бол гадаад улсаас зөвшөөрүүлэхийг та дурлахгүй байна уу, энэ тухай асуултыг ямар нэгэн хийг мартаж үл болмой. Эдгээр зүйлс дотроо танай тусгаар гадаад улсын төлөөлөгчид лүгээ ярилцаагүй буюу гэсэнд,

Гэндэнгээс: Тийм ээ энэ тухай хэнтэй боловч ямар ч хэлэлцээнийг хийгээгүй болой, зарим этгээдээс гадаад «японы зүгээс» батлуулахыг хүссэнд тийм этгээдийг бид нар таны мэдсээр тэр тухай яллаж байсан болой, Ер гадаадаас батлуулахыг оролдох нь хэрэгтэй эсэх тухай танд тодорхой амой, юун хэмээвээс Бүгд Найрамдах Монгол Ард Улсыг гадаадаас батлах асуулт нь дотоодын хэрэг бус олон улсын хоорондох асуулт болно, Жич тэмдэглэхэд олон улсын зүгээс батлуулахыг миний бие хүсдэг бололтойгоор энд мэдэгдсэн Учир эдгээр асуулт гарч болох шалтгааныг дурьдваас 1932 онд эсэргүү бослогоос хойш шинэ эргэлтийг явуулах сацуугаар бидний Монгол удирдах ажилчдаас Богд Уулын амралтын газар цай ууж хамтран ярилцахын дашрамд завсраа ярилцсан нь улс төрийн чанар байдлаар манай Монгол улс нь ямар улс лугаа ойролцоо болохыг ярилцахуй дор тэр тухай миний хэлсэн нь, манай Монгол улс болбол СССР улс лугаа ч ойролцоо бус, баячуудын бүгд найрамдах улс лугаа ч ойролцоо бус харин СССР лугаа ойр холбоо бү-

хий Турк улс лугаа ойролцоо байж болмой, гэсэн бөгөөд, бодоход миний ийнхүү хэлсэн зүйлээс зарим нөхөд намайг Түркийн төлөөлөгчийг урьж энэ улс лугаа холбоо тогтоохыг хүсэж буй хэмээн бодсон биз хэмээсээнд,

Нөхөр Сталинаас; Танай улсын албан ёсоор тогтнох явдал нь та нараас олон Улсын баталгааг олж авсан цагт сая болно. Хэрэв тийм баталгааг та нар олж чадах ахул ер түүнд муу юм үгүй болой, юуны урьд хятадаас тусгаар тогтносон хэмээхийг зарлуулах нь та нарт хэрэгтэй болой. Жич Хятадын зүгээс өөрийн тусгаар тогтносныг батлуулан авч чадаад мөн бусад улсаас нэгэн адил батлуулан авч чадвал Та нар нь Барга, Цахар хийгээд бусад Монголын мужуудын доторд монголчуудыг татах төв болж чадах бөгөөд тэдгээр нь Монголын жинхэнэ тусгаар тогтносон явдал танайд байна гэдгийг мэдэх болно. Хэрхэн ийм байдалд хүрэх вэ хэмээвээс нэгд та нар өөрийн улсыг хүчтэй болгох хэрэгтэй, юун хэмээвээс одоо үед таны засаг хүчтэй юм уу, эсхүл лам нарын засаг хүчтэй болохын алин нь сайн мэдэгдээгүй байна. Ийм байхад бусад улс яаж таныг батлах вэ ийм байдал тун тусгүй болой.

Иймийн тулд юуны урьд та нараас эрхбиш Улс ёсоор батжих хэрэгтэй. Цэргийг хүчтэй болгох, ардын аж ахуй, эдийн засаг ба, соёл боловсролын хэмжээг өндөр болгох зэргээр та нар ийнхүү батжилтыг олж хүчтэй Улсын ёсоор улс болж чадваас тэр тухайд Хятадаас өөрийн тусгаар тогтносон тухай албан ёсоор зарлуулж болно. Тэр тухайд Япон, Энгельш (Англи) ба бусад эзэрхэг түрэмгий Улсуудаас өөрсдөө өөрийн санаачлагаар таныг батлахыг эрмэлзэх болмой, Хэрэв батлахгүй боловч та нар хүчтэй болсон тул тэд нараас айхгүй байж болно. Иймд хамгийн чухал нь хүчтэй болох хэрэгтэй хэмээсэнд,

Нөхөр Молотовоос: Бид нар боловч урьд бас ийм байдалтай байсан бөгөөд СССР-ийг хэн боловч батлахыг дурлахгүй байсан болой. Одоо ахул та нарын мэдсээр бид нар бүх улсуудад батлагдсан ба Лигнацид орсон амой хэмээсэнд.

Нөхөр Сталинаас: Тийм бодлогыг та нараас хүчтэй болсон тухайд сая олж авмой, Түүний тулд та нараас эрхбиш зохих суурь бэлтгэлийг тогтоох хэрэгтэй болой. Эрхбиш хатуужилтай цэрэгтэй болох хэрэгтэй.

Тийнхүү хүчтэй болмогц та нараас албан ёсоор Хятадаас салж өөрийн тусгаар тогтносон тухай зарлаж болох бөгөөд, тэр үед та нарыг хятадаас довтлохоо айх болно. Үүний хэмт мөн дотооддоо бат бэх улс болох хэрэгтэй. Лам нарыг өөрийн гартаа чангаар барьж авах хэрэгтэй. Хүчтэй улс болж чадсан тухайд ба хатуужилтай цэрэгтэй болж чадсан тухайд Хятадаас та нарыг довтлохоосоо айх болно. Чадалгүй этгээдийг цохидог ба чадалтай этгээдийг ойшоож үздэг хэмээхийг мартаж үл болмой. Эдээр зүйлс дотроо танай тусгаар тогтнох асуудлын гол үндсэн утга нь оршмой. Жич та Түркийн тухай дурьдсан бөгөөд үүнд Турк ба танай улсын хооронд ихээхэн ялгавартай болой. Түркийн дотор засгийн га-

зар нь баячууд помещик байдаг бөгөөд Улсын дотор ноёдуудыг хэвээр үлдээсэн амой, Танай улсад болбаас засгийн газраа ардын этгээд сууж байгаа бөгөөд Танай засгийн газар нь арддаа Түркээс ойр болой. Танай ноёдууд болбаас бидний мэдсээр хятадад оргож одсон бөгөөд тэд нарт Бүгд Найрамдах Монгол Ард Улсын дотор орших газаргүй амой, Ийм бага бус ялгавартай болох нь үзэгдэж амой,

(МАХН-ын Төв Архив, тусгай фонд, Уйгуржин монгол бичгээр тэмдэглэсэн гар бичмэл эхээр С, Дамдинсүрэн хэвлэлд бэлтгэв),